

**БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2026 ОНЫ БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

2026 оны 06 дугаар сарын 08

Хөхбүрд

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж буй бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Зорилго 1. Иргэдийн амьдрах, сурч хөгжих орчныг сайжруулах							
Зорилт 1.1. Дэд бүтцийг сайжруулах, бүтээн байгуулалтыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:							
1	1.1.1.Сумын түүхт 80 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах, бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллах	-	Гүйцэтгэлийн хувиар	-	100%	Сумын түүхт 80 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах салбар хороодыг сумын Засаг даргын 2026 оны А/27 дугаар захирамжаар байгуулж, салбар хороо тус бүр ойн арга хэмжээний хүрээнд хийгдэх ажлын ажлын төлөвлөгөө боловсруулан баталгаажуулж ажиллаж байна	70%
2	1.1.2.Хүүхдийн тоглоомын талбайг стандартын дагуу засварлах, хүлээж авах, гүйцэтгэлд хяналт тавих	50,0 сая	Гүйцэтгэлийн хувиар	-	100%	Хүүхдийн цэцэрлэгийн тоглоомын талбайн тоглоом бусад тоног төхөөрөмжийг 49,8 сая төгрөгөөр “Би Би Ди Эм” ХХК хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.	100%
3	1.1.3.Наадмын талбайг засварлан шинээр барьж ашиглалтад оруулах, гүйцэтгэлд хяналт тавих.	400,0 сая	Гүйцэтгэлийн хувиар	-	100%	Наадмын талбайг засварлах ажлыг аж ахуйн нэгж, иргэдийн хандвиар хийхээр төсөв санхүүг бүрдүүлж байна.	50%
4	1.1.4.Сумын төвд хатуу хучилттай зам талбайг байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих	1,900,0 сая	Гүйцэтгэлийн хувиар	-	100%	Сумын төвийн хатуу хучилттай замын ажлыг “Анагай” ХХК хийж гүйцэтгэж байна. Одоогоор ажлын гүйцэтгэл 50%, санхүүжилтийн 45% олгосон.	50%

1	2	3	4	5	6	7	8
5	1.1.5.Сумын төвийн гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, нарны цамхаг байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих	150,0 сая	Гүйцэтгэлийн хувиар	-	100%	Сумын төвийн гэрэлтүүлгийг ажлын тендерт Хишиг төгөлдөр ХХК шалгарч, 132,8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хийхээр гэрээ байгуулан ажиллаж байна.	50%
6	1.1.6.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор камержуулах ажлыг хэрэгжүүлэх.	50,0 сая	Гүйцэтгэлийн хувиар	-	100%	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын төвийн орчныг камержуулах ажлын тендерт “Динамик лайн” ХХК шалгарч 95,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хийхээр гэрээ байгуулан ажиллаж байна.	50%
7	1.1.7.Нутгийн удирдлагын ордонг барьж бүрэн ашиглалтад оруулах, гүйцэтгэлд хяналт тавих.	Хандив 750,0 сая	Гүйцэтгэлийн хувиар	-	100%	Нутгийн удирдлагын ордоны өргөтгөлийн ажил 70 хувьтай хийгдсэн боловч санхүүжилт ороогүй тул ажил одоогоор зогссон байна.	70%
Зорилт 1.2. Иргэд олон нийтийг соён гэгээрүүлэх, нийгмийн оролцоог дэмжих, хөгжих боломжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:							
8	1.2.2.Малчид төлчид, тариаланчдын зөвлөгөөнийг зохион байгуулан иргэдийг мэдээллээр хангах соён гэгээрүүлэх олон талт арга хэмжээг зохион байгуулах.	Засаг даргын нөөц хөрөнгөөс 6,538,5	Гүйцэтгэлийн хувиар	100%	100%	Сумын Засаг дарын 2026 оны А/04 дүгээр захирамжаар “Таван-Эрдэнэ малчид төлчид, тариаланчдын зөвлөгөөн”-ийг 2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулсан. Тус зөвлөгөөний үеэр сумын цолтой 32 бөхийн бариалдаан, Үндэсний шагайн наадгайн буухиа, дартс тэмцээн тус тус зохион байгуулсан. Уг арга хэмжээнд нийт 306 малчид оролцсон.	100%
9	1.2.3.Улс, аймаг, сумын аварга малчид, тариаланчдыг тодруулан урамшуулах, алдаршуулах ажлыг зохион байгуулах.	-	Гүйцэтгэлийн хувиар	100%	100%	Улсын аварга малчин 2, Аймгийн аварга малчин 4, сумын аварга малчин 13, сумын аварга саальчин 6-ыг тус бүр тодруулсан.	100%
Зорилго 2.Сум орон нутгийн бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төрийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах							
Зорилт 2.1.Цахим системийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах зорилтын хүрээнд							
10	2.1.1.Хүний нөөцийн удирдлага мэдээллийн	-	Гүйцэтгэлийн хувиар	100%	100%	Хүний нөөцийн удирдлага мэдээллийн системид байгууллагын бүтэц орон тоо болон төрийн	30%

1	2	3	4	5	6	7	8
	нэмэгдүүлэн албан хаагчдын мэдээллийг бүрэн цахимжуулах					тушаалын зорилго, зорилтыг оруулж төрийн албаны салбар зөвлөлөөр хянуулахаар илгээсэн.	
11	2.1.2.Баян-Овоо сумын нэгдсэн bayanovoo.bkh.gov.mn цахим сайтын хэвийн үйл ажиллагааг хангаж мэдээллийг бүрэн байршуулж хэвших.	-	Гүйцэтгэлийн хувиар	30%	100%	Сумын нэгдсэн цахим хуудас bayanovoo.bkh.gov.mn сайтын хэвийн үйл ажиллагааг хангаж мэдээллийг тухай бүрд нь бүрэн оруулж байна. 2026 онын хагас жилийн байдлаар нийт 236 мэдээлэл байршуулсан байна.	100%
12	2.1.3.Shilen.gov.mn сайтад мэдээллийг бүрэн байршуулан ашиглалт хамгаалалтыг сайжруулах.		Гүйцэтгэлийн хувиар	30%	100%	Нээлттэй мэдээллийн ил тод байдлыг хангаж shilen.gov.mn системд мэдээллийг бүрэн байршуулж 2026 оны 01 дүгээр улиралд 81% хувьтай үнэлэгдсэн.	80%
13	2.1.4.E-Office программын ашиглалтыг сайжруулан бичиг төлөвлөлт болон өргөдөл гомдлын бүртгэлийг хөтөлж цахимжуулах, улирал бүр мэдээг нэгтгэн холбогдох газарт хүргүүлэх.	-	Гүйцэтгэлийн хувиар	30%	100%	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл гомдлыг E-Office программд бүртгэн холбогдох албан тушаалтнаар хуулийн хугацаанд шийдвэрлүүлэхээр шилжүүлэн хааж ажиллаж байна. 2026 оны 01 дүгээр улиралд 11 өргөдөл, 2 дугаар улиралд 24 өргөдөл бүртгэгдсэн ба шийдвэрлэлтийн мэдээг хугацаанд нь хүргүүлсэн.	70%
14	2.1.5.Төрийн байгууллагын зүгээс цаг үеийн мэдээллийг ил тод байршуулан сумын ойн арга хэмжээтэй холбоотой хандив өгсөн иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг алдаршуулах болон бүтээн байгуулалтын арга хэмжээг цаг тухай бүр ил тод байршуулах	-	Гүйцэтгэлийн хувиар	-	100%	Төрийн байгууллагуудын цаг үеийн мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээх ЗДТГ-2026 фэйсбүүр цахим хуудсаар түгээсэн. Сум үүсгэн байгуулагдсаны түүхт 80 жилийн арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдаж буй арга хэмжээний мэдээлэл болон хандив өргөсөн иргэд, аж ахуйн нэгжийг алдаршуулах мэдээллийг 2026 оны 02 дугаар сараас эхлэн “Баянхонгор аймгийн Баян-овоо сум 80 жил” фэйж хуудсанд байршуулж ажиллаж байна.	80%

1	2	3	4	5	6	7	8
15	2.1.6.Иргэдэд цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулах	-	-Олголтын хувиар	80%	90%	Сумын хэмжээнд нийт давхардсан тоогоор 1123 иргэнд тоон гарын үсэг олгосон.Энэ оны хагас жилийн байдлаар 53 иргэнд тоон гарын үсэг олгосон давхар иргэдэд киоск машинаар тоон гарын үсэг олгож ажиллаж байна. Нийт хүн амын 87% тоон гарын үсэг олгосон.	87%
16	2.1.7.Операторын үйлчилгээг иргэдэд сурталчлан, төрийн үйлчилгээг цахимаар авах боломжийг нэмэгдүүлэх.	-	-Лавлагаа мэдээлэл олголтын тоо	300	400	Сумын хэмжээнд операторын үйлчилгээ болон киоск машинаар эхний хагас жилээр 100 ш лавлагаа гаргаж ажиллаж байна. Тоон гарын үсгийг утас дээр суулгаж, заавар зөвлөмж өгч ажиллаж байна.	30%
2.2.Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, нийгмийн баталгааг хангах зорилтын хүрээнд:							
17	2.2.1.Суралцагч сум арга хэмжээний хэрэгжилтийг ханган жил бүр шаардагдах төсвийг батлуулах.	1,0 сая	Гүйцэтгэлийн хувиар	80%	100%	Сумын Засаг даргын 2026 оны А/22 дугаар Захирамжаар Суралцагч сум арга хэмжээний төлөвлөгөө, хэрэгжүүлэх ажлын хэсгийг томилон арга хэмжээний зардалд 4,000,000 төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гарцуулахаар батлуулсан. Суралцагч сум арга хэмжээний 4 дэд арга хэмжээг төсөвт байгууллагуудад хуваарилан хэрэгжүүлж байна.	70%
18	2.2.2.Албан хаагчдын Нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулан ажлын байранд сурч хөгжих боломжийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах.	-	-сургалтын тоо -хамрагдсан албан хаагчийн тоогоор	-2 100-	- 6 -100	Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хамтын гэрээний датгуу албан хаагч болон ар гэрт нэг удаагийн тэтгэмж 6 удаа буюу 1,892,000 төгрөгийг олгосон. Мөн 3 албан хаагчдын ур чадварын нэмэгдэл олгон ажиллаж байна.	50%
19	2.2.3.Албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийг нэмэгдүүлэх сургалтад хамруулах ажлыг хэрэгжүүлэх.	-	-Зохион байгуулсан сургалтын тоо хамрагдсан албан хаагчдын тоо	-1 -25	-2 -30	Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг 3,4 дүгээр улирлын дотоод сургалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Хугацаа болоогүй	Х.Б

1	2	3	4	5	6	7	8
20	2.2.4. "Чанартай боловсрол-Чадварлаг төрийн албан хаагч" хөтөлбөрийг хэрэгжүүлэн хүний нөөцийн бодлогыг дэмжих	100,0 сая	-хөтөлбөрийн хэрэгжилтээр	50%	100%	Хугацаа болоогүй	Х.Б
21	2.2.5. Сумын төсөвт байгууллагын уялдаа холбоог хангах үүднээс улирал бүр хяналт үнэлгээ, зөвлөн туслах, туршлага солилцох ажлыг хэрэгжүүлэх.	-	-Улирал бүр зохион байгуулсан ажлын тоо	2	4	Сумын Засаг даргын 2026 оны Сумын төрийн байгууллагуудын 2026 оны 01 дүгээр улирлын үйл ажиллагаанд Хяналт шинжилгээ, үнэлгээ, зөвлөн туслах арга хэмжээ зохион байгуулах тухай" 19 дүгээр удирдамжийн дагуу Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Наранцэцэгээр ахлуулсан ажлын хэсэг 2026 оны 04 дүгээр сарын 13-17-ны өдрүүдэд Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төв зэрэг төсөвт 4 байгууллагын 01 дүгээр улирлын үйл ажиллагаанд Бодлогын баримт бичиг хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээ, Байгууллагын чиг үүргийн үзүүлэлт, Архив, албан хэрэг хөтлөлт, Салбар бүрт чиглэсэн дотоод үйл ажиллагааны хүрээнд 2 зорилтын 33 үзүүлэлтээр хяналт шалгалт, зөвлөн туслах ажлыг зохион байгуулж ажиллалаа. Хяналт шалгалтын ажлын хүрээнд байгууллага бүрийн ажлын үр дүн, явцад 0-3 оноогоор үнэлгээ дүгнэлт өгч зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэн зөвлөмж хүргүүлэсэн.	50%
22	2.2.6. Байгууллагын эцэг эхийн зөвлөлийн хэвийн үйл ажиллагааг хангаж, төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг хангах, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх,	-	-Гүйцэтгэлийн хувиар	70%	90%	Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийг 2026.01.07-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан ба энэ оны ажил үйлчилгээг эрэмбэлж нийт 15 төлөвлөсөн. Төлөвлөгөөт ажлын нэг болох хүйтэн сэрүүний улиралтай холбогдуулан дархлаажуулалтын аяныг өрнүүлж байгууллагын ажилтан албан хаагчдын 52 хүүхдэд 10,000 төгрөгийн багцыг бэлдэж олгосон. Мөн аймгийн засаг даргын	50%

1	2	3	4	5	6	7	8
						2019.09.25-ны өдрийн А/494 дүгээр захирамжийн хүрээнд ажилтан албан хаагчдын хүүхдүүдийн төрсөн өдөр нь болж байгаа үед нэг өдрийн цалинтай чөлөөг олгож хэвшсэн. Он гарснаас хойш нийт 8 ажилтанд тус чөлөөг олгосон байна.	
23	2.2.7. Ёс зүйн дэд хорооны хэвийн үйл ажиллагааг хангаж төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж холбогдох газарт мэдээ тайланг хугацаанд нь хүргэж ажиллах	-	-Гүйцэтгэлийн хувиар	70%	90%	Ёс зүйн дэд хороо нь анхдугаар хурлаа зохион байгуулж, ёс зүйн дэд хорооны 2026 онд хэрэгжүүлэх 19 арга хэмжээ бүхий үйл ажиллагааны төлөвлөгөө, MNS 7068:2025 “Төрийн албаны үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага” –ийг хэрэгжүүл төлөвлөгөөг тус тус боловсруулан батлуулж нэгдүгээр улиралын тайланг байгууллагын даргад хүргүүлсэн. Мөн ёс зүйн дэд хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг төрийн албаны цахим нэгдсэн системд оруулж баталгаажуулсан. Ёс зүйн дэд хорооноос төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр долоо хоног болгоны 4 дэхь өдөр бүр Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, Төрийн албаны үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага зэрэг сэдвээр 4 удаа 26 албан хаагчийг хамруулан сургалт орсон. Мөн Ерөнхий боловсролын сургууль болон Соёлын төвийн төрийн албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ сэдвээр сургалт орж нийт 30 албан хаагч хамрагдсан.	90%
Зорилт 2.3. Архив албан хэрэг хөтлөлтийн хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зорилтын хүрээнд:							
24	2.3.1. Байгууллагын 2026 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулан Төрийн архивын хэлтсийн дэргэдэх БНШАЗК-ийн хурлаар хэлэлцүүлж батлуулах	-	Гүйцэтгэлийн хувиар	100%	100%	Баримт нягтлан шалгах комиссоор 1 дүгээр улиралдаа багтаан Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг хэлэлцэн Төрийн архивын хэлтэсрүү явуулсан.	100%

[illegible]

1	2	3	4	5	6	7	8
31	2.4.1.Сумын ОНХС, ХХС-аас олгосон зээл, хөтөлбөр, төслийн холбогдох зээлийг төлүүлэх.	-	-Зээлийн эргэн төлөлтийн хувь	70%	100%	Сумын ОНХС-аас хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллаж, ХХС-аас олгосон зээлийн эргэн төлөлтөд анхаарч зээлийн эргэн төлөлтийг хоршоонуудаас төлүүлэх арга хэмжээг авч байна.	80%
32	2.4.2.Сумын төрийн байгууллагуудын төлбөр тооцооны гүйлгээг цахимаар хянаж Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах.	-	-гүйцэтгэлийн хувиар	80%	100%	Сумын төрийн байгууллагуудын төлбөр тооцооны гүйлгээг цахимаар хийж,хянаж баталж, төрийн сангийн удирдлагын цахим систем (Finance.gov.mn), санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн систем (Finerfojm.mof.mn) зэргийг нягтлан бодох бүртгэлдээ хэрэглэж, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж хэвшээд байна	100%
33	2.4.3.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж төсөвт байгууллагуудын өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах		-хэрэгжилтийн хувиар	80%	100%	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж, төсөвт байгууллагуудын өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулан хагас бүтэн жилийн хөрөнгийн тооллогыг тогтмол хийж,байгууллагуудын өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлыг чанаржүүлэн ажиллаж байна.	100%
34	2.4.4.Сумын 2026 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, төрийн худалдан авах ажиллагааг цахим системээр төлөвлөн хэрэгжүүлэх	-	-гүйцэтгэлийн хувиар	100%	100%	Сумын 2026 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, төрийн худалдан авах ажиллагааг цахим системээр төлөвлөн хэрэгжүүлэн ажиллаж хагас жилийн байдлаар худалдан авах төлөвлөгөөний биелэлт 95% тэй байна.	95%
35	2.4.5.Сумын 2026 оны төсвийн татварын орлогын төлөвлөгөөг орлогын нэр төрөл тус бүрээр биелүүлэх	-	-орлогын биелэлтийн хувиар	90%	100%	Татварын болон татварын бусад орлого эхний 5 сарын байдлаар 919 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 1,8 тэрбум төгрөгийн орлого төвлөрч 197,2 хувийн гүйцэтгэлтэй байна. Нэр төрлөөр нь авч үзвэл Цалин хөдөлмөрийн хөлстэй адилтгах орлого 1,640,157.3 мянган төгрөг 200 хувь, Үйл ажиллагааны орлого 34320,4 мянган төгрөг 343,2%, ҮХЭХ борлуулсны орлого 33,6 мянган төгрөг 3,4%, Хадгаламжийн хүүгийн орлого 3782,8 мянган төгрөг 37,8%,	100%


1	2	3	4	5	6	7	8
						Үл хөдлөх хөрөнгийн орлого 46304,4 мянган төгрөг 308,7%, Малын тоо толгойн албан татвар 16816,7 мянган төгрөг 37,4%, Газрын төлбөр 58661 мянган төгрөг 2346,4%, Хог хаягдлын үйлчилгээний хураамж 2130 мянган төгрөг 67,6%-ийн гүйцэтгэлтэй байна.	
Зорилго 3. Хөдөлмөр эрхлэлт, Халамжийн бодлогыг иргэдэд хүртээмжтэй ил тод хүргэх.							
Зорилт 3.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж шаардлагатай төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:							
36	3.1.1.Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт, авлага барагдуулалтыг графикайн дагуу зохион байгуулах.	-	-эргэн төлөлтийн гүйцэтгэлийн хувиар	100%	100%	Энэ оны хэмжээнд 8 төслийг хүлээн авч 3 төсөл нь 23,000,000 төгрөгийн санхүүжилт авсан. Хоршооны нэг төсөл 10,000,000, хөгжлийн бэрхшээлтэй нэг иргэний төсөл 5,000,000, ахмадын нэг төсөл 8,000,000 тус бүр дэмжигдсэн.Төсөл хөтөлбөрийн хүрээнд 14 шинэ ажлын байрыг гаргаж ажилласан. Мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд нийт 20,656,000 төгрөгийн эргэн төлөлтийг хийсэн. Үүнд малжуулах төсөлд хамрагдсан 10 малчны 14,000,000 төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний төсөлд хамрагдсан 2 иргэний эргэн төлөлт 2,000,000 төгрөг, Ахмад настны төсөлд хамрагдсан 2 иргэний эргэн төлөлт 3,965,000 төгрөгийн эргэн төвлөрүүлэлтийг тус тус хийсэн	70%
37	3.1.2.ХАБЭА-ийн чиглэлээр албан байгууллага, аж ахуйн нэгжид эрсдлийн үнэлгээг улирал бүр хийж сургалт мэдээлэл өгч зөрчлийг арилгуулсан байх.	-	-үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувиар	50%	100%	ХАБЭА-ийн чиглэлээр удирдамжийн дагуу байгууллагуудаар 2 удаа хяналтаар явж зөвөлгөө мэдээлэл өгсөн. Онцгой байдлын газраас эрсдэлийн үнэлгээг эрүүл мэндийн төв дээр хийсэн. Цахилгааны аюулгүй байдал, хүүхэд ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт сэдвээр дотуур байрны 45 хүүхдэд орсон. Уранхайрхан 2 дугаар багийн хуралд малчны хөдөлмөрийн аюулгүй байдал сэдэвт сургалтыг 50 малчин иргэнд орсон.	50%
Зорилт 3.2. Нийгмийн халамжийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх зорилтын хүрээнд:							
38	3.2.1.Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд хамрагдаж	-	-Үйл ажиллагааны үр дүнгийн хувиар	-80%	100%	Энэ онд шинээр нийгмийн халамжийн тэтгэвэрт 10 иргэн, тэтгэмжинд 9 иргэнийг хамруулж шинээр хувийн хэргийг нээж баталгаажуулсан.	80%

1	2	3	4	5	6	7	8
	буй иргэдийн анхан шатны материалыг хүлээн авч хувийн хэрэг нээж, баяжилтийг хууль, журмын дагуу хийж иргэнд үйлчилгээг хүргэх.					Баяжилтыг 23 хувийн хэрэгт хийсэн ба он гарснаас хойш ажил үүрэгтэй холбоотой 125 өргөдөлийг цахим, утас, цаасаар хүлээн авч шийдвэрлэж ажилласан.	
Зорилго 4. Хөдөө аж ахуйн салбарын хууль тогтоомжийг сум орон нутгийн онцлогт нийцүүлэн хэрэгжүүлэх							
Зорилт 4.1. Мал аж ахуй эрхлэгч, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилтын хүрээнд:							
39	4.1.1. Газар тариалангийн салбарын үйл ажиллагааг дэмжиж, нийт тариалалт хийгдсэн 10 га талбайгаас 21 тн ургац хураан авах.	-	-Ургацын хувиар	100%	100%	Ерөнхий боловсролын сургууль, Баянбардан хоршоо гэсэн 2 тариалалт хийсэнээр төмс 1 га, лууван 0,3 га, манжин 0.1 га, лооль 0,001 га, өргөст хэмх 0,001 га тариалалт хийсэн байна.	70%
40	4.1.2. Малыг эрүүлжүүлэх, удмын санг сайжруулах, нутгийн шилмэл омог үүлдэрийн малыг өсгөн эдийн засгийн эргэлтэд оруулж, таваарлаг чанарыг сайжруулна.	-	Үйл ажиллагааны хувиар	70%	75%	Хугацаа болоогүй	Х.Б
41	4.1.3. Мал аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэлийг зохион байгуулах	-	Хувиар	90%	95%	Хугацаа болоогүй	Х.Б
42	4.1.4. "Намрын ногоон өдрүүд" үзэсгэлэн худалдаа зохион байгуулан ажиллах	-	-Арга хэмжээний тоо	1	1	Хугацаа болоогүй	Х.Б
43	4.1.5. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, аж ахуйн нэгж, иргэн дэмжих зорилгоор гэрээгээр ашиглуулах болон түрээслэх боломжтой тоног төхөөрмжийн мэдээллийг иргэдэд хүргэх	-	-Арга хэмжээний тоо	1	1	Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, аж ахуйн нэгж, иргэн дэмжих зорилгоор гэрээгээр ашиглуулах болон түрээслэх боломжтой тоног төхөөрмжийн мэдээллийг иргэдэд хүргэн ажиллаж 2 иргэнд гэрээгээр оёдолын машин түрээслэсэн.	80%

1	2	3	4	5	6	7	8
44	4.1.6.Худалдаа үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжид хүнсний аюулгүй байдлыг хангах талаар хяналт шалгалт хийж мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх	-	Мэдээлэл хүргэсэн иргэдийн тоо	-	200	Хүнсний худалдаа үйлчилгээ эрхэлдэг, төрийн болон төрийн бус байгууллагуудад хүнсний аюулгүй байдал, импортын бүтээгдэхүүний сав баглаа боодол, эрүүл ахуйн хяналт шалгалтыг сумын хэрэглэгчийн эрхийг хамгаалах салбар зөвлөлөөс зохион байгуулан хүнсний худалдаа, эрүүл ахуйн чанар, стандартын байдлыг хангаж ажиллаж байгаа байдалд хяналт шалгалтыг хийж зөрчлийг арилгуулах, зөвлөмж, зөвлөгөө өгөх ажлыг 2 удаа зохион байгуулж ажилласан. Ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид болон Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад, Сургуулийн сурагчдад Хүнсний бүтээгдэхүүний хаяг шошго, Хүнсний аюулгүй байдал, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулиар сургалт зохион байгуулж 35 албан хаагч 48 сурагч хамрагдсан.	50%
45	4.1.7.Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн эргэн төлөлт, зориултад хяналт тавих	-	Гүйцэтгэлийн хувиар	-	70%	Хоршоо хөгжүүлэх сангийн хяналтын зөвлөл нь 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдөр хуралдаж Хоршоо хөгжүүлэх сангаас 2025 онд 3 хоршоо 120 сая төгрөг, 2022 онд 2 хоршоо 2013 онд зээл 1 иргэн зээлийн эргэн төлөлтөнд хяналт тавьж ажилласан.	30%
46	4.1.8.Сумын хэрэглэгчийн эрхийг хамгаалах салбар нийгэмлэгийн үйл ажиллагааг хангах.	-	Зохион байгуулсан ажлын тоогоор	4	4	Хэрэглэгчийг эрхийг хамгаалах салбар нийгэмлэгийн 2026 оны ажлын төлөвлөгөөг 9 арга хэмжээ бүхий боловсруулан батлуулж хүнсний аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд 9 аж ахуйн нэгжийг хамруулсан хяналт шалгалтыг 2 удаа хийж зөрчлийг арилгуулах, зөвлөмж, зөвлөгөө өгч ажиллаа. Засаг даргын Тамгын газрын даргын 2026 оны 05 дугаар сарын 19-ны 27 дугаар удирдамжаар “Эрсдэлгүй хүнс” урьдчилан сэргийлэх аянг 2026 оны 05 дугаар сарын 18-наас 2026 оны 06 дугаар сарын 18-ны хооронд өрнүүлж аянд иргэн аж ахуйн нэгж бусад төрийн байгууллагуудыг нэгдэхийг уриалан ажилласан. Тус аяны хүрээнд Баян-овоо сумын ерөнхий боловсролын сургуулийн дунд бүлгийн 7-9 ангийн 48 сурагчдад Хүнсний	50%

1	2	3	4	5	6	7	8
Зорилт 4.2. Мал амьтны халдварт болон шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:							
						байгуулж эхний 3 байрт шалгарсан хүүхдэд өргөмжлөл үнэ бүхий зүйлээр шагнасан.	
47	4.2.1.Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг технологит хугацаанд тархвар зүйн зураглалын дагуу зохион байгуулан ажиллах	-	- Дархлаажуулалтын хувиар	30%	100%	Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 242300 толгой мал, амьтан хамруулахаас 101766 толгой мал, амьтанг хамруулан ажиллаж байна.	40%
48	4.2.2.Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг /Угаалга, Туулга, Боловсруулалт/ 4 багийн хэмжээнд нийт мал сүргийг хамруулан чанартай зохион байгуулан ажиллах.	-	-Хамрагдалтын хувиар	30%	- 100%	Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 244890 толгой мал, амьтанг хамруулахаас 84624 толгой мал, амьтанг хамруулан ажиллаж байна.	30%
49	4.2.3.Мал, амьтны сэг зэм устгал, бэлчээр, хашаа хороог стандарт заавар журмын дагуу халдваргүйтгэл хийж гүйцэтгэх	-	-Халдваргүйтгэлийн хувиар	100%	-	Энэ жил хорогдол бага гарсан учир бог малын сэг зэмийг малчид өөрсдөө зориулалтын газар нь устгалыг хийж гүйцэтгэсэн.	100%
Зорилго 5.Байгаль орчныг хамгаалах, хяналтыг сайжруулах, хэрэгжүүлэх							
Зорилт 5.1.Ногоон байгууламжийг нэмэгдүүлж байгаль орчинд ээлтэй бодлогыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:							
50	5.1.1.“Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Сумын хэмжээнд тарьсан 20.000 модны ургалтыг нэмэгдүүлэх	-	-Ургалтын хувиар	30%	70%	2026 оны 04 дүгээр сарын 17ний өдөр Аймгийн Байгаль орчны газрын моджуулалт ой мод хариуцсан мэргэжилтэн Б.Хандсүрэн мэргэжилтэн Т.Сэвжиддулам Баян-Овоо сумын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Эрдэнэванчин сумын ойн зурвасын модыг тарьсан Вело Трэйд ХХК ны захирал Цогтбаяр Наранмандал ХХК ны байгаль орчны ахлах мэргэжилтэн Б.Цогтгүн хамтран модны ургалтыг тогтоох, нэгдсэн тооллогыг зохион	90%

1	2	3	4	5	6	7	8
						сумын ойн зурвасын модыг тарьсан Вело Трэйд ХХК ны захирал Цогтбаяр Наранмандал ХХК ны байгаль орчны ахлах мэргэжилтэн Б.Цогтгүен хамтран модны ургалтыг тогтоох, нэгдсэн тооллогыг зохион байгуулахад модны ургалт 30 хувьтай 98 хувь нь амьд байсан ба 37708 ширхэг мод 4.8 га газарт ургаж буй нь тоологдсон Вело трэйд ХХК-ны гэрээт ажилчин Цэдэвсүрэн тогтмол усалгаа арчилгааг хариуцаж ажиллаж байна.	
51	5.1.2.Ариун цэврийн байгууламжийг сайжруулах, Нийтийн эзэмшлийн гудамж талбай, хүүхдийн тоглоомын талбай, үйлчилгээний газруудад иргэд үйлчлүүлэх эко 00-ыг байгуулах	30,0 сая	-Эко ариун цэврийн байгууламжийн тоо	0	20	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөнөөр ариун цэврийн байгууламжийг сайжруулах, Нийтийн эзэмшлийн гудамж талбай, хүүхдийн тоглоомын талбай, үйлчилгээний газруудад иргэд үйлчлүүлэх эко 00-ыг байгуулах ажилд тендэр зарлан сонгон шалгаруулалтын шатанд хэрэгжиж байна.	30%
52	5.1.3.Хог хаягдлын менежментийг сайжруулан айл өрхийн хашаанд нэгдсэн журмаар ангилан ялгах хогийн савтай болгож нийтийн эзэмшлийн газарт хог хаягдлыг ангилан ялгах савийг байршуулах.	-	-Байршуулсан хогийн савны тоо	10	30%	Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс 49,368,000 төсөвт өртөгөөр сумын төвийн гэр хорооллын 1 дүгээр гудамны 21 өрх болон 2 аж ахуйн нэгжид стандарт бүхий ангилан ялгах хогийн савийг хийж суурилуулсан.	70%

ХЯНАСАН
 ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
 ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Б.НАРАНЦЭЦЭГ

ХЭРЭГЖИЛТ НЭГТГЭСЭН
 НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН  Ө.АРИУНЗАЯА